



ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2026.01.22 № 04

**Завхан - Увс аймгийн чиглэлийн
А18 дугаартай авто замын талаар**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

Завхан аймгийн Сонгино сумаас Увс аймгийн Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулснаар Увс аймаг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар бүрэн холбогдсон. 2021 оноос тус замын зорчих хэсгийн асфальтобетон хучилт эвдэрч, Улаанбаатар талаасаа ПК553-573 хооронд нийт 20 км авто замд 15,684 мкв нүхэн эвдрэл үүссэн байна. Газар нутгийн байршлаар замын засвар, үйлчилгээг хариуцсан Завхан АЗЗА ТӨХК нь эвдрэл, гэмтлийг засварлаагүйгээс зорчиж буй иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсоор байгаа талаар тус замаар зорчдог иргэд болон миний бие санал, гомдлоо удаа дараа албан бусаар илэрхийлсээр ирсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулсан. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 14 дүгээр зүйлд тус тус зааснаар Засгийн газрын үйл ажиллагаа, Засгийн газрын гишүүний төсвийн удирдлагын талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийг тогтоож өгсөн.

Иймд Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хүрээнд замын эвдрэлийг засварлахад 2021 оноос хойш авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тулгараад байгаа асуудал, гарц шийдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хүсэж байна.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ЗАЯАБАЛ

2026000010